



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/160

Бор-Өндөр сум

**Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс
хөрөнгө зарцуулах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.4.1 дэх заалт, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 3.4.4 дахь заалт, Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бор-Өндөр сумын 4 дүгээр багт “Үерийн далан, замын байгууламж дээгүүр явган хүний гүүрэн гарц хийх” ажлын зураг төслийн хяналтын ажлыг хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулсан “Урантод” ХХК-д санхүүжилт болох 514,796 (таван зуун арван дөрвөн мянга долоон зуун ерин зургаа) төгрөгийг олгосугай.

2. Тус ажлын санхүүжилт болох 514,796 (таван зуун арван дөрвөн мянга долоон зуун ерин зургаа) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс зарцуулахыг Санхүүгийн албаны дарга (Э.Түвшинсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ

ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ГАЛБАДРАХ